



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ  
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY



ХЭРЭГЛЭЭНИЙ  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
СУРГУУЛЬ



## АЛСЫН ХАРАА

ДЭЛХИЙД ҮНЭЛЭГДЭХ :  
ОЮУНЫ ҮНЭ ЦЭНИЙГ  
БҮТЭЭНЭ



## ЭРХЭМ ЗОРИЛГО

ЭХ ОРНЫ ХӨГЖЛИЙН ГАРЦЫГ ТОДОРХОЙЛОХ  
ХҮН-БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ШИНЖЛЭХ УХААН,  
ТЕХНОЛОГИЙН МЭДЛЭГ, ИННОВАЦИЙГ БҮТЭЭХ  
АВЬЯАС ЧАДВАРЫН ТӨВЛӨРӨЛ БАЙНА.



## ҮНЭТ ЗҮЙЛС

ШУТИС-ИЙН ХАМТ ОЛОН (ПРОФЕССОР БАГШ,  
СУДЛААЧ, СУРАЛЦАГЧ, ТӨГСӨГЧ) БИД ЭРХЭМ  
ЗОРИЛГОО БИЕЛҮҮЛЭХИЙН ТУЛА ДАРААХ ҮНЭТ  
ЗҮЙЛСИЙГ БАРИМТЛАН, ДАГАЖ МӨРДӨНӨ.



## УРИА

АСУУДЛЫГ  
БҮТЭЭЛЧЭЭР ШИЙДЬЕ!

## ШУТИС-ЛАГ БАЙЯ



### ШИЛДЭГ ГҮЙЦЭТГЭЛ

EXCELLENCE

Бид бүтээлч сэтгэлгээ, ур чадварт тулгуурлан тогтсон  
стандартаас давсан үр дүнгээр манлайлагч байна.



### УЛАМЖЛАА

TRADITION

Бид өнгөрсөн, одоо, ирээдүйн залгамж холбоог  
дээдэлсэн, шинэчлэлийг эрэлхийлэгч байна.



### ТЭМҮҮЛЭЛ

INSPIRATION

Бид эрхэм зорилгоо биелүүлэхийн төлөө  
тасралтгүй тэмүүлэгч байна.



### ИННОВАЦИ

INNOVATION

Бид шинийг санаачлагч, оюуны бүтээлийг үйлдвэрлэл, үйлчилгээнд  
нэвтрүүлэгч, энтрепренер байна.



### САЙН-ХҮМҮҮНЛЭГ ЗАСАГЛАА

HUMANE GOVERNANCE

Бид шинийг санаачлагч, оюуны бүтээлийг үйлдвэрлэл, үйлчилгээнд  
нэвтрүүлэгч, энтрепренер байна.

## ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

01

СУРАЛЦАХҮЙН  
ШИНЭЧЛЭЛ БА  
КАРЬЕР ХӨГЖИЛ

02

СУДААЛГААНЫ  
ТӨГӨЛДӨРШИЛ

03

ИННОВАЦИ,  
ТЕХНОЛОГИ  
АРИЛЖААЛААЛТ

04

НИЙГМИЙН  
ХАРИУЦЛАГА

05

ЗАСАГЛАА,  
МЕНЕЖМЕНТИЙН  
ШИНЭЧЛЭЛ





Хэрэглээний Шинжлэх Ухааны сургуулийн үе үеийн эрдэмтэн профессор, багш, ажилтан албан хаагчид болон нийт төгсөгч, оюутан, элсэгч та бүхэндээ энэ өдрийн мэнд дэвшүүлье.

Монгол улсад инженер-техникийн боловсон хүчин бэлтгэх зорилгоор Политехникийн Дээд Сургуулийн анхны салбарууд бий болсон үеэс суурь шинжлэх ухааны тэнхимүүд үүсэж улмаар 1991 онд Инженерийн Суурь Боловсролын Төв, 1997 онд Инженерийн Суурь Боловсролын Сургууль, 2001 онд Математикийн сургууль, Материал Технологийн сургууль, 2014 оноос Хэрэглээний Шинжлэх Ухааны Сургууль болон үйл ажиллагаа нь өргөжсөн.

Манай сургуулийн хамт олон ШУТИС-ийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн шинэ технологи, мэдээллийн эрин зуунд өндөр боловсролтой, хүн-байгальд ээлтэй инженер технологийн мэргэжилтэн бэлтгэх ажилд хичээнгүйлэн зүтгэж байна. Улс эх орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлагыг мэдэрч сургалт-судалгаа-үйлдвэрлэлийг нягт уялдуулах замаар мэдлэгийг хэрэглээ болгох, инновацийг бүтээх эрхэм зорилготой.

Энэхүү эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд сургалтын хөтөлбөр, хичээлийн стандарт, агуулгыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, бүтээлч, шинийг санаачлагч, манлайлагч, хүмүүнлэг энэрэнгүй мэргэжилтэн бэлтгэх, нийт багш судлаачдын оюуны өмчийн бүтээл, эрдэм шинжилгээ судалгааны ажил болон мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж олон улсын түвшинд хүрэх зорилтууд тавин ажиллаж байна.


Бидний үйл ажиллагааг дэмжин хамтран ажилладаг байгууллага, хамт олон, хувь хүмүүс, оюутан залуус, элсэгчид та бүхэнд ШУТИС-ийн ХШУС-ийн хамт олны өмнөөс сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

*Эрдмийн гэгээн цйле өрнүүн дэлгэрэж болтугай.*

Доктор (Ph.D), дэд профессор В.Өлзийбаяр



## БАГШЛАХ БОЛОВСОН ХҮЧИН



Хэрэглээний Шинжлэх Ухааны Сургуулийн нийт багш ажилтнуудын 43% эрдмийн зэрэг цолтой





## ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС



## БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ





## СУРГАЛТЫН ХӨТӨЛБЭРҮҮД

Манай сургууль ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын бакалаврын хөтөлбөрт тусгагдсан математик, физик, хими, биеийн тамир зэрэг дээд боловсролын суурь хичээлүүд болон ХШҮС-ийн бакалавр, магистр, докторын хөтөлбөрүүдийн сургалтыг зохион байгуулдаг.

Хамрагдах боломжтой тэтгэлэг болон зээл, тусламж

“Ректорын нэрэмжит” тэтгэлэг

“Захирлын нэрэмжит” хуудсаар 1-5 кредитийн урамшуулал

Боловсролын зээлийн сангийн буцалтгүй тусламж

Оюутны хөгжлийн зээл

Голомт банк болон бусад байгууллагуудын тэтгэлэг

### Бакалавр

- Химийн технологи
  - Газрын тосны боловсруулалтын технологи
  - Нүүрсний боловсруулалтын технологи
  - Органик бус бодисын химийн технологи
- Химийн инженерчлэл,
- Химийн инженерчлэл, БНХАУ-тай хамтарсан 2+2
- Материал судлал
- Статистик
- Статистик, БНХАУ-тай хамтарсан 2+2
- Үйлдвэрийн экологийн инженер,
- Үйлдвэрийн экологийн инженер, БНХАУ-тай хамтарсан 2+2
- Наношинжлэх ухаан инженерчлэл
- Хэрэглээний физик
- Инженерийн бэлтгэл-Герман хэл /2 жил/

### Магистр


- Химийн технологи
- Нүүрсний боловсруулалтын химийн технологи
- Газрын тосны боловсруулалтын технологи
- Ховор ба үнэт металлын химийн технологи
- Материал судлал, шинэ материалын технологи
- Хэрэглээний математик
- Системийн динамик загварчлал
- Инженер физик
- Физик экологи

### Доктор

- Химийн технологи
- Нүүрсний боловсруулалтын химийн технологи
- Газрын тосны боловсруулалтын технологи
- Ховор ба үнэт металлын химийн технологи
- Силикатын химийн технологи
- Хэрэглээний математик
- Инженер физик (физик технологи / онолын физик загварчлал)
- Плазмын технологи



# МАТЕМАТИКИЙН ТЭНХИМ



Математикийн тэнхим нь ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын хөтөлбөрүүдийн дээд боловсролын математикийн суурь хичээлүүд болон өөрийн хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдийн мэргэжлийн хичээлүүдээр оюутанд үйлчилдэг. Тус тэнхим нь өгөгдөл боловсруулалт, машин сургалт, инженерийн тооцоо судалгаа хийх программ хангамжуудтай өндөр хүчин чадлын компьютерийн лабораториудтай бөгөөд эдгээр нь интернетийн сүлжээнд холбогдсон, проектор, дэлгэц, гэрэл гэх мэт шаардлагатай төхөөрөмжүүд суурилуулсан, тус бүр нэг ээлжиндээ 30 оюутан хичээллэх хүчин чадалтай, тус лабораториудад оюутнууд судалгааны ажил тооцоолол, уралдаан тэмцээнд бэлдэх, төслийн болон төгсөлтийн ажлуудыг хийж гүйцэтгэдэг.

### Математик загварчлалын лаборатори



Байгалийн болон нийгэм эдийн засгийн аливаа юмс үзэгдлийн хууль, бүтэц, зүй тогтлыг математик загвар ашиглан турших, симуляц хийх, гаргасан загварын алдааг үнэлэх, үр дүнгээ тооцоолж сурах, ашиглах, арга дадлыг олгоно. Уг лаборатори нь инженерийн процессын тооцоололд ашиглагддаг шилдэг программ хангамжууд, MATLAB, Portran, Latex, Texplot, нийлмэл процесс, өгөгдөл боловсруулах Python, Nvidia зэрэг программ хангамжуудтай

### Математик тооцооллын лаборатори



Инженерийн болон байгаль, эдийн засгийн аливаа үйл явцыг бүхэлд нь болон хэсэгчлэн компьютер ашиглан тооцоолох, алдааг үнэлэх, үр дүнгээ харьцуулах, процессийн алдааг үнэлэх, ашиглах, алдаа багатай удирдах арга замыг олох өгөгдөл боловсруулалт, машин сургалт, гүн сургалтын тооцоолуудыг хийж сурах арга дадлыг олгоно.

# ФИЗИКИЙН ТЭНХИМ



1

Профессор

5

Дэд  
профессор

17  
MSc

17  
Ph.D

Нийт 34 багш  
ажилтантай

150  
гаруй

Ном сурах бичиг

900  
гаруй

Эрдэм шинжилгээний  
өгүүлэл

4

Хөтөлбөр,  
мэргэжил





Физикийн тэнхим нь сургалтын 4, судалгааны 3 нийт 7 лабораторитой. Ерөнхий эрдмийн ба мэргэжлийн суурь мэргэшүүлэх хичээлүүдийн лабораторийн туршилтын ажлууд, төгсөх ангийн оюутны судалгааны ажлыг доорх лабораториудад хийж гүйцэтгэдэг.

### Механикийн лаборатори



Классик механикийн тулгуур хууль үзэгдлийн ойлголтыг бататган, туршлага дээр шалгаж, онолын мэдлэгийг практикт хэрэглэх, багаж төхөөрөмж дээр хэмжилт туршлага хийх дадал олгож, тооцоо боловсруулалт хийх арга ажиллагаанд сургана.

### Молекул физикийн лаборатори



Молекул физикийн хууль үзэгдлийн зүй тогтлыг туршлагаар судалж шалгах, практикт хэрэглэх хэмжилтийн явцад гарах алдааг тооцоолж үр дүнгээ тооцож сурах арга дадлыг олгоно.

### Цахилгаан ба соронзонгийн лаборатори



Цахилгаан соронзон үзэгдлийн хуулиудыг туршлагаар судалж шалгах, цахилгаан схемийг бие даан угсарч, шалгаж сурах, туршилтын үр дүнг боловсруулах арга ажиллагаанд сургана.

### Оптик, цөмийн физикийн лаборатори



Оптик болон атом цөмийн физикийн үзэгдлүүдийг туршлага дээр шалган онолын мэдлэгийг бататган гүнзгийрүүлэх, оптик багаж хэрэгсэлтэй танилцан, тэдгээрийг хэрэглэн хэмжилт хийж сурах, физик туршилтыг бэлтгэх, явуулах хэмжилтийн үр дүнг боловсруулах арга барил, дадал чадвар эзэмшүүлнэ

## Нанотехнологийн лаборатори



Эрдэс түүхий эд, бодис, материалын кристалл бүтэц, найрлагын судалгаа, 1нм-10000нм-ийн мужид бөөмийн хэмжээс ба түүний тархалт, тогтворжилтийн судалгаа, Монгол орны эрдэс түүхий эд, түүгээр үйлдсэн бүтээгдэхүүний физик шинж чанар, технологийн судалгаа явуулж улс болон олон улсын нэр хүндтэй сэтгүүлүүдэд хэвлүүлж байна.

## Физик загварчлалын лаборатори



Уур амьсгалын өөрчлөлт болон загварчлал, хиймэл дагуулын мэдээ ашиглан тал хээрийн бүс нутгийн ууршилтыг загварчлах, хиймэл дагуулын мэдээ боловсруулалтын технологи, газарзүйн мэдээллийн системийн чиглэлээр судалгаа явуулж улс болон олон улсын хамтарсан төслүүдийг хэрэгжүүлж байна.

## Гадаргуугийн судалгааны лаборатори



Хэт өндөр вакуумын болон агаарын орчинд материалын гадаргуугийн бүтцийг атомын түвшинд хүртэл судалж тодорхойлох бөгөөд мөн түүний дээр хэдэн зуугаас нэг атомын үе хүртэл атомын нимгэн үе үүсгэн судлах боломжтой ба судалгааны үр дүнг оюутны курс, дипломын ажил цаашлаад магистр докторын судалгааны ажилд ашиглах боломжтой.

## ҮЛ ЭВДЭХ СОРИЛЫН ТӨВ



ҮЭС-ийн лабораторид үйлдвэрийн радиографийн шалгалт, хэт авианы сорил, соронзон бөөмийн сорил, шингэн нэвчүүлэх сорил, металын ширээлтийн үл эвдэх сорил, бетоны үл эвдэх сорил зэрэг үндсэн шинжилгээнүүдийг хийж байна.



# БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТЭНХИМ



1

Олон улсын  
шүүгч

2


Олон улсын спортын  
мастер

3

Спортын мастер

1

Монгол улсын начин



Нийт 11 багш  
ажилтантай





## Сагсан бөмбөг

Хөдөлгөөний дутагдал болон оюуны хөдөлмөрийн ачааллаас үүсч болох, ядаргаанаас урьдчилан сэргийлэх улмаар эрүүл чийрэг сурч хөдөлмөрлөх бололцоог хангана.

Бие бялдрын чанаруудыг хөгжүүлэх, сагсан бөмбөгийн спортын техник элементэд суралцахад оршино.



## Волейбол

Волейболын спорт нь оюутны бие бялдрыг хөгжүүлэн, эрүүл мэндээ бэхжүүлэх, тэсвэр хатуужилтай, ачаалал даах болон багаар ажиллах чадварт сургадаг.

Бие бялдрын бэлтгэлжилт нь хөдөлгөөний үйлдлийг гүйцэтгэх бие бялдрын чадавх юм. Бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх, бэлтгэлжилтийн төвшингээ насан туршдаа хадгалж, идэвхтэй хөдөлгөөн, спортыг амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон төлөвшүүлэхэд нөлөөлнө.



## Эмчилгээний биеийн тамир

Эрүүл мэндийн хувьд ердийн биеийн тамирын хичээлд хамрагдах боломжгүй суурь өвчтэй, суурь өвчлөлийн хүндрэлийн үед болон бусад олдмол хэв шинжтэй хүнд мэс засал, хугарал гэмтэл, харвалт, саажилт, хавдар гэх мэт эрүүл мэндийн байдлаас хамаарч бие бялдрын боловсролыг эзэмшүүлэх, аливаа өвчнөөр үүсгэгдсэн бэрхшээлийг даван туулах, нөхөн сэргээх, бие махбодын хөгжлийн үзүүлэлтүүдийг нэмэгдүүлэх, амин чухал чадвар, дадлыг биеийн тамираар дамжуулан олгоход энэхүү хичээлийн зорилго оршино.



## Тэшүүр

Тэшүүрийн спорт нь цэвэр агаарт оюутны бие бялдрыг хөгжүүлж тэсвэр хатуужилтай, ачаалал даах чадварт сургадаг. Бие бялдрын бэлтгэлжилт нь хөдөлгөөний үйлдлийг гүйцэтгэх чадавх юм. Тэшүүрийн спортын техник элементэд суралцахад оршино. Тэшүүрийн спортыг олон нийтэд сурчлан таниулах, оюутнууд бие бялдрын төвшингээ насан туршдаа хадгалж, идэвхтэй хөдөлгөөн болгон төлөвшүүлэхэд тэшүүрийн хичээлийн зорилго оршино.



# ХИМИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН САЛБАР



1

Профессор

7

Дэд  
профессор

15  
MSc

16  
Ph.D

Нийт 31 багш  
ажилтантай

140  
гаруй

Ном сурах бичиг

810  
гаруй

Эрдэм шинжилгээний  
өгүүлэл

6

Хөтөлбөр,  
мэргэжил



Манай салбар нь сургалтын 7, судалгааны 4 нийт 11 лабораторитой. Ерөнхий эрдмийн ба мэргэжлийн суурь мэргэшүүлэх хичээлүүдийн лабораторийн туршилтын ажлууд, төгсөх ангийн оюутны судалгааны ажлыг доорх лабораториудад хийж гүйцэтгэдэг.

### Нефтийн боловсруулалтын лаборатори



Нефтийн буюу газрын тосыг атмосферийн болон вакуум нэрлэгт оруулж бензин болон дизелийн түлшний фракциуд, тос, гудрон зэргийг гарган авах боломжтой. Атмосферийн нэрлэгээр гарган авсан түлшний фракциудын нягт, найрлага, хүхрийн агуулга, ханасан уурын даралт, механик хольц, усанд уусдаг хүчил шүлт зэрэг чанар ба ашиглалтын гол үзүүлэлтүүдийг стандартын дагуу бүрэн тодорхойлдог.

### Аналитик химийн лаборатори



Аналитик химийн лаборатори нь аналитик химийн хичээлийг судалж буй оюутнуудад химийн бодисын тоо ба чанарын найрлагыг тогтоох лабораторийн ажлуудыг хийж гүйцэтгэхээс гадна төгсөх оюутны дипломын туршилт судалгааг хийдэг.

### Химийн үйлдвэрлэлийн процесс ба аппаратын лаборатори



Химийн ба байгалийн түүхий эдийг боловсруулах үйлдвэрүүдэд ашиглагдах хагас ба бүрэн автомат горимоор ажилладаг тоног төхөөрөмжүүдийн багасгасан хувилбар дээр химийн технологийн урсгалын үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлж компьютерийн системээр үйлдвэрлэлийн технологийн процессыг хянах чадвартай инженерүүдийг бэлтгэх үндсэн хичээлүүдийн туршилтууд хийдэг

### Багажит шинжилгээний лаборатори



Органик ба органик бус химийн бодисын сорьц дээжийн химийн шинжилгээг багажит анализын аргаар гүйцэтгэнэ. Сорьц дахь элементийн шинжилгээ, фазын шинжилгээ, функционал бүлгүүд тогтоох шинжилгээ, хувийн гадаргуу, нүх сүвийн хэмжээ тогтоох боломжтой сургалт, эрдэм шинжилгээнд ашиглагддаг лаборатори юм.



## Шатах ашигт, малтмалын боловсруулалтын лаборатори



Газрын тос, нүүрс, байгалийн хий, занарын гүн боловсруулалтын технологи, тоног төхөөрөмжийн тооцоо сонголт, процессын загварчлалын чиглэлээр судалгаа явуулж Улс болон олон улсын хамтарсан төслүүд хэрэгжүүлж, үр дүнгээр дотоод, гадаадын нэр хүндтэй сэтгүүлүүдэд эрдэм шинжилгээний өгүүлмүүд хэвлүүлээд байна. Мөн түүхий эд болон бүтээгдэхүүний физик, химийн шинж чанарыг стандарт аргачлалын дагуу тодорхойлох боломжтой сургалт, судалгааны лаборатори юм.

## Материал судлалын төв



Материал судлал, шинэ материалын салбарын бакалавр, магистр, доктор оюутны сургалт, дадлагын ажил, оюутны эрдэм шинжилгээ, зохион бүтээх ажлыг дэмжин оролцох ба холбогдох профессорын баг, тэнхим, салбартай хамтран ажиллах болон салбарын мэргэжилтний мэргэшүүлэх сургалт явуулдаг.

## Ахисан түвшний сургалтын лаборатори



Хүрээлэн буй орчин, усны чанар ба найрлага, бохирдолт, ус боловсруулах технологийн чиглэлээр төсөл, судалгааны болон гэрээт ажил хийхээс гадна эрдэм шинжилгээ, гэрээт ажлыг гүйцэтгэх боломжтой уг лабораторид Монгол орны гадаргын болон газар доорх усны судалгааны чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажилладаг ба магистр доктор оюутны судалгааны ажлыг гүйцэтгэдэг.



<http://www.sas.edu.mn>



## ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

ХШУС нь гадаад харилцаагаа өргөжүүлж сургалт, эрдэм шинжилгээ, оюутан солилцоо, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжил дээшлүүлэх, туршлага солилцох, хамтарсан хөтөлбөр, судалгааны төслүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

### Математикийн тэнхим нь

- БНХАУ-ын Баруун Хойд Политехникийн Их Сургууль
- ХБНГУ-ын Дармштадын Техникийн Их Сургууль, Дрездений Техникийн Их Сургууль
- БНСУ-ын Ионсей Их Сургууль
- Польш улсын Шинжлэх ухааны Академийн Математикийн хүрээлэнгийн Банах төв
- Австри улсын Венийн ТИС
- Болгар улсын Софи хотын ХТИС, ТИС
- ОХУ-ын Москва мужийн Дубна дахь ЦШНИ

### Физикийн тэнхим нь

- БНХАУ-ын Нанжин Аж Үйлдвэрийн Их Сургууль
- БНСУ-ын Чонбук их сургууль
- Италийн Лаквагийн Их Сургууль
- ОХУ-ын Бауманы нэрэмжит Москвагийн Их Сургууль
- Япон улсын Үндэсний Материалын Шинжлэх ухааны Институт, Фукуй Их Сургууль, Китаюшюгийн их сургууль

### Химийн инженерчлэлийн салбар

- Японы Нийгата их сургууль, Мияконожо Үндэсний Технологийн Дээд Сургууль, Кейо Их Сургууль, Нунтагийн технологийн мэдээллийн төв, Акита Их Сургууль
- ОХУ-ын Москвагийн Их Сургууль, Нефть ба хийн Их Сургууль, Эрхүүгийн ТИС, Дорнод Сибирийн ТИС
- БНХАУ-ын Бээжингийн Их Сургууль, Бээжингийн Аж Үйлдвэрийн Их Сургууль, Бээжингийн Нефтийн Их Сургууль, Өвөрмонголын Аж Үйлдвэрийн Их Сургууль, Инчуаны Эрчим Хүчний Сургууль, Нанжин Аж Үйлдвэрийн Их Сургууль, Шанхайн Технологийн Их Сургууль, Баруун хойд Политехникийн Их Сургууль
- АНУ-ын Өмнөд Дакотагийн УТС
- БНСУ-ын Чонбук их сургууль, Инчеоний Их Сургууль
- Голландын Амстердамын Их Сургууль

## ХОЛБОО БАРИХ

### Захирал:

В.Өлзийбаяр Ph.D доктор, дэд профессор  
Утас: 11-322283, 11-324590 (2301)  
И-мэйл: v\_ulzii@must.edu.mn  
Өрөө: 1-410

### Дэд захирал:

Б.Тунгалагтамир Ph.D доктор, дэд профессор  
Утас: 11-324590 (2302)  
И-мэйл: botungalagtamir@must.edu.mn  
Өрөө: 1-411

### Эрдэмтэн нарийн бичгийн дарга:

Д.Отгонбаяр Ph.D доктор  
И-мэйл: dotgonbayar@must.edu.mn  
Өрөө: 1-420

ХАЯГ: ШУТИС-ийн төв байр, Багатайруу 34,  
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо